



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/65

Зуунмод сум

「 Аудитын тайлан баталгаажуулах тухай 」

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, УИХ-ын төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 8 дугаар тогтоол, МУЕА-ын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162 дугаар тушаал, 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Төв аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн “Газар олголт, эрх шилжүүлэлтийн байдал 2019-2023 он” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Н.Энхболд, аймгийн Засаг дарга Л.Төмөрчөдөр нарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор Ж.Бямбацогт-д үүрэг болгосугай.
3. Аудитаар илэрсэн зөрчилд өгөгдсөн 910,926.0 мянган төгрөгийн 42 төлбөрийн акт, 10,448,780.2 мянган төгрөгийн 43 албан шаардлага, хариуцлага тооцуулах нэг албан шаардлага, ажил сайжруулах 4 зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Б.Насанжаргал/-д зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Ж.Бямбацогт, Ц.Саранчимэг нарт үүрэг болгосугай.
5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг гүйцэтгэлийн аудитын багийн аудитор Д.Бямбасүрэн, Б.Адьяасүрэн нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

G/Архив/Албан бичиг 2024/ Tushaal

019011059

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГАЗАР ОЛГОЛТ, ЭРХ ШИЛЖҮҮЛЭЛТИЙН
БАЙДАЛ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/30-3-ШТА-ГА

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: : khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273465 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272287 Цахим хаяг: sararchimegts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёг	2
Графикын товъёг	2
Зургийн товъёг	2
Товчилсон үгийн тайлбар	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилт	4
Аудитын хамарсан хүрээ, хугацаа	4
Аудитын хязгаарлалт	4
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	4
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	5
Үндсэн мэдээлэл	5
Хүндрэл бэрхшээл	7
БҮЛЭГ 1. ГЭР БҮЛИЙН ХАМТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫГ ХУУЛЬД ЗААСАН ХЭМЖЭЭНЭЭС ХЭТРҮҮЛСЭН, ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ЭЗЭМШҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ БУУРАХГҮЙ БАЙНА.....	8
А.1 Аймаг, сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө батлахдаа аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баримтлаагүй байна.....	8
А.2. Гэр бүлийн хамтын хэрэгцээний газрыг ГЗБТ-нд тусгаагүй байршилд олгосон, хуульд заасан газрын хэмжээнээс илүү эзэмшүүлсэн зөрчил арилаагүй байна.	10
А.3. Иргэн, хуулийн этгээдэд 552,2 сая төгрөгийн анхны үнэтэй 221 га газрыг дуудлага худалдаагүй эзэмшүүлсэн байна.....	12
БҮЛЭГ 2. ГАЗРЫН ЭРХ ШИЛЖҮҮЛСНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР, ГАЗРЫН ТӨЛБӨР, УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙГ НОГДУУЛААГҮЙ, ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	17
Б.1. Аймгийн хэмжээнд 2019-2023 онд 24,151.2 га газрыг дуудлага худалдаагаар эзэмшүүлж, төсөвт 23,345.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.	17
Б.2. Газар эзэмшүүлэх, эрх шилжүүлэх, эрхийн гэрчилгээг сунгахтай холбоотой татвар, хураамжийг иргэн, ААН-д ногдуулж төсөвт төвлөрүүлээгүй байна.	18
Б.3. Газрын төлбөрийг бүрэн ногдуулж, төсөвт төвлөрүүлээгүйгээс 2,330.0 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.....	19
БҮЛЭГ 3. ГАЗРЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ЭРХ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД СУМДЫН ИТХ-ААС ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	22
В.1. Мэргэжлийн байгууллагаас газар олголт, ашиглалтай холбоотой хяналт шалгалтыг хийж зөрчлийг арилгуулж байгаа боловч зөрчлийг давтан гаргасаар байна.	22

В.2. Газрын нэгдмэл санд бүртгэсэн, газрын кадастрын нэгдсэн систем хөтлөх үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн байна.	23
ДҮГНЭЛТ:	25
ЗӨВЛӨМЖ:	26
Хавсралт:.....	28

Хүснэгтийн товьёг

Хүснэгт 1. Төв аймгийн газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал /га-аар/	6
Хүснэгт 2. Газар тариалангийн бүс нутаг.....	6
Хүснэгт 3. ГЗБЕТ-ний газрын нэгдмэл сангийн өөрчлөлт.....	8
Хүснэгт 4. Гэр бүлийн хамтын хэрэгцээгээр олгосон газрын судалгаа	11
Хүснэгт 5. Иргэн ААН-д эзэмшүүлсэн газар /зориулалтаар/	13
Хүснэгт 6. Эрх шилжүүлсэн газар /зориулалтаар/	18
Хүснэгт 7. Газрын эрх шилжүүлсний орлогын албан татварын дутуу төлөлт.....	19
Хүснэгт 8. Өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газрын ангилал	24

Графикын товьёг

График 1. ГЗБТ-г мэдээллийн санд оруулсан байдал /нэгж талбараар/	7
График 2. Газрын олголтын зөрчлийн ангилал	13
График 3. Газрын дуудлага худалдааны орлого.....	17
График 4. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/	20
График 5. Төв аймгийн газрын нэгдмэл сан /га/	23
График 6. Төв аймгийн газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдал.....	24

Зургийн товьёг

Зураг 1. Батсүмбэр сумын усан сан бүхий газрын суурьшлын бүс.....	9
Зураг 2. Газрын хувийн хэргийн хадгалалтын байдал.....	11
Зураг 3. Баянчандмань сум 2.24 газрыг 1 иргэнд 0.07 га-аар 32 захирамж гаргаж олгосон газар	12
Зураг 4. Алтанбулаг сум Туул голын эрэг дагуу жимс жимсгэнэ зориулалттай газар	15
Зураг 5. Батсүмбэр сум Сөгнөгөрийн голын эрэг дагуу аялал жуулчлалын зориулалттай газар.	16

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуй нэгж
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БЗОСК	Барилга захиалагч, орон сууцны корпорац
ГБХХ	Гэр бүлийн хамтын хэрэгцээ
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар
ГЗБЕТ	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө
ГЗБТ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө
ГТХ	Газрын тусгай хэрэгцээ
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МТА	Монголын татварын алба
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Хөдөө аж ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/101 дугаар тушаал болон Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжүүлсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг Аймгийн Засаг дарга, ИТХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Дээрх зорилтын хүрээнд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Газар эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг үр дүнтэй төлөвлөж, зохион байгуулсан уу?
- Газрын харилцаатай холбоотой хуулиар тогтоосон албан татвар, төлбөр, хураамжийг ногдуулж, бүрэн барагдуулсан уу?
- Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж байна уу?

Аудитын хамарсан хүрээ, хугацаа

Төв аймгийн нутаг дэвсгэрт газар олгох, эрх шилжүүлэхтэй холбоотой Улаанбаатар хоттой хил залгаа, газрын эрэлт ихтэй сумдыг /Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Баянхангай, Заамар, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Эрдэнэ, Мөнгөнморьт, Сэргэлэн, Зуунмод/ түүвэрлэн сумын ИТХ, Засаг дарга, ГХБХБГ, Татварын хэлтэс, УБХ, газрын даамал, мөн газрын харилцааны чиглэлийн бусад байгууллага, албан тушаалтны 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамруулж, тухайн байгууллага, албан тушаалтны газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдох шийдвэр, хувийн хэрэг, баримт материалыг түүвэрлэн шалгасан.

Аудитын хязгаарлалт

Засгийн газрын шийдвэрээр зарим газрыг улсын тусгай хамгаалалтад авах үйл ажиллагааг аудитын түүвэрт хамруулаагүй, хязгаарласан болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, дугаар стандартууд, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817- 7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу”-ыг баримтлан аудитад хамрагдсан байгууллагуудаас авсан мэдээлэл, нэгж талбарын хувийн хэрэг, газрын кадастрын мэдээллийн сан болон цуглуулсан нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, лавлагаа, тайлбар авах, дүн шинжилгээ, түүвэрлэлт хийх зэрэг арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгаа, тайланг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд

- Газрын тухай хууль;
- Хот байгуулалтын тухай хууль;
- ХХОАТ-ын тухай хууль;
- ААНОАТ-ын тухай хууль;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
- Газрын төлбөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”;
- Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Газрын улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”;
- ГХГЗЗГ-ын даргын 2009 оны 224 дүгээр тушаалаар баталсан “Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам”;
- ГХГЗЗГ-ын даргын 2011 оны 171 дүгээр тушаалаар баталсан “Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах журам”;
- Төв аймгийн ИТХ-ын 2017 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн IV хуралдааны 01 тогтоолоор баталсан “Хөгжлийн түүчээ – Төв аймаг – 2024 аймгийн хөгжлийн хэтийн зорилт”
- Төв аймгийн ИТХ-ын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 дугаар хуралдааны 04 тогтоолоор баталсан “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Бямбацогт, Ц.Саранчимэг аудитор Г.Баянжаргал, Д.Бямбасүрэн, Т.Хүрэлбаатар, Б.Адъяасүрэн нар гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2024 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 11 дүгээр сарын 15-ны өдрөөс тус тус эхлүүлэн гүйцэтгэж, аудитын тайланг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ, Засаг дарга, ГХБХБГ, Төв аймгийн татварын хэлтэст хүргүүллээ.

Үндсэн мэдээлэл

Төв аймаг нь Монгол Улсын дорнод төв хэсэгт 74,042.37 км² газар эзлэн оршдог. Нутаг дэвсгэрийнхээ дунд хэсэгтээ Нийслэл Улаанбаатар хотыг хүрээлж, бусад талаараа Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ зургаан аймагтай хиллэнэ. Нийт нутгийн 109,036.7 га буюу 1,5 хувийг хот, тосгон бусад суурин газар, 18,1 хувийг ой, 0,2 хувийг усан сан бүхий газар эзэлдэг байна.

Хүснэгт 1. Төв аймгийн газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал /га-аар/

№	Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал	Газрын талбайн хэмжээ	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
1	Хөдөө аж ахуйн газар	5,860,682.5	79.2
2	Хот тосгон бусад суурин газар	109,036.7	1.5
3	Зам шугам сүлжээний газар	78,973.4	1.1
4	Ойн сан бүхий газар	1,339,258.4	18.1
5	Усны сан бүхий газар	16,286.0	0.2
Аймгийн нийт талбай		7,404,237.0	100.0

Эх сурвалж: ГХБХБГ-ын 2023 оны газрын нэгдмэл сангийн тайлан

Аймаг, сумын Засаг даргын захирамжаар 2019-2023 оны хугацаанд нийт 12849 нэгж талбарт 11645,6 га газрыг гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар шинээр эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн бол 25641 нэгж талбарт 9254,1 га талбай бүхий газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар эзэмшүүлж, 21 нэгж талбар бүхий 2,415.4 га газрыг гэрээний үндсэн дээр эзэмшүүлж, ашиглуулахаар шийдвэрлэжээ.

"Тариалангийн бүс нутаг тогтоолгох тухай" Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг үндэслэн МУЗГ-ын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор баталсан тариалангийн бүс нутагт Төв аймгаас 11 сумын газар нутаг бүхэлдээ, 2 сумын 5 багийн нутаг дэвсгэр багтсан байна.

Хүснэгт 2. Газар тариалангийн бүс нутаг

д/д	Сумын нэр	Баг
1	Аргалант	Сумын газар нутгийн хэмжээнд
2	Архуст	Сумын газар нутгийн хэмжээнд
3	Батсүмбэр	Сумын газар нутгийн хэмжээнд
4	Баянхангай	Сумын газар нутгийн хэмжээнд
5	Баянцогт	Сумын газар нутгийн хэмжээнд
6	Баянчандмань	Сумын газар нутгийн хэмжээнд
7	Борнуур	Сумын газар нутгийн хэмжээнд
8	Жаргалант	Сумын газар нутгийн хэмжээнд
9	Сүмбэр	Сумын газар нутгийн хэмжээнд
10	Угтаалцайдам	Сумын газар нутгийн хэмжээнд
11	Цээл	Сумын газар нутгийн хэмжээнд
12	Эрдэнэсант	1, 2, 3, 4 дүгээр баг
13	Заамар	1 дүгээр баг

Эх сурвалж: МУЗГ-ын 2018 оны 131 дүгээр тогтоол

МУЗГ-ын 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 273 дугаар тогтоол, МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.7.7-д "Шинэ Зуунмод", "Майдар" шинэ хотуудын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ" гэж тусгасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт 12000 га газрыг "Майдар хот" төсөл хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авч, газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг баталсан байна.

МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.7-д "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ", 3.7.3-д "Хиймэл оюун ухаан болон блокчейн, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангасан технологид суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг

хөгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлнэ” гэж тусгасан байна. Энэ ажлын хүрээнд 2020 оноос газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем www.egazar.gov.mn цахим хуудас, “E-Gazar” системийг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь Монгол Улсын Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын цахим үйлчилгээний систем юм. Энэ систем нэвтэрснээр иргэн, ААНБ өөрийн эзэмшиж буй газартай холбоотой газрын мэдээллийг цахимаар авах, газрын төлөвлөлт, бүртгэл зэрэг 72 төрлийн мэдээллийг авах бөгөөд 23 төрлийн өргөдлийг цахимаар илгээх боломжтой болж төрийн үйлчилгээг хялбаршуулсан байна.

Газрын кадастрын нэгдсэн цахим систем нэвтэрсэнтэй холбоотой ГЗБТ-г цахимд байршуулах ажлыг Төв аймгийн ГХБХБГ-аас зохион байгуулан ажилласнаар 2020-2023 онд 20,6-57,2 хувь хүртэл нэмэгдүүлсэн байна.

График 1. ГЗБТ-г мэдээллийн санд оруулсан байдал /нэгж талбараар/



Хүндрэл бэрхшээл

2024 онд УИХ болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн жил давхацсантай холбоотой шалгагдагч байгууллагын албан тушаалтан, газрын даамал нар сонгуулийн хэсгийн хорооны гишүүнээр томилогдон ажилласан нь аудит хийх цаг хугацааг удаашрах нөхцөл болсон байна.

БҮЛЭГ 1. ГЭР БҮЛИЙН ХАМТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫГ ХУУЛЬД ЗААСАН ХЭМЖЭЭНЭЭС ХЭТРҮҮЛСЭН, ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ЭЗЭМШҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ БУУРАХГҮЙ БАЙНА.

А.1 Аймаг, сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө батлахдаа аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баримтлаагүй байна.

Аймгийн ИТХ-ын бүрэн эрхийг Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэн батална”, Хотын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д “бүс нутгийн хөгжлийн төслийн үндсэн шийдэлтэй уялдуулан орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах” гэж заасан байна.

Төв аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолоор “Лапланд эко” ХХК-иар хийлгэсэн “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г 637 хуудас бүхий 3 боть, 76 хуудас бүхий зураглалын каталогийг баталсан байна. Уг ерөнхий төлөвлөгөөнд аймгийн ИТХ-ын 2017 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн IV хуралдааны 01 тогтоолоор баталсан “Хөгжлийн түүчээ – Төв аймаг – 2024 аймгийн хөгжлийн хэтийн зорилт” хэмээх 8 жилийн хугацаанд 2017-2020, 2021-2024 оноор хоёр үе шаттай хэрэгжүүлэх баримт бичигтэй нийцүүлсэн боловч зарим зүйл нь зөрчилдсөн, тоон мэдээлэл нь зөрүүтэй байна. Тухайлбал “Атрын III аян”-ыг үргэлжлүүлэн тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж, газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэн бүтээгдэхүүний чанар, нэгжээс авах ургацыг нэмэгдүүлнэ гэж тусгасан байхад ГЗБЕТ-ний 12 дугаар бүлэг “Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт”-т 2030 онд Төв аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хэрэгжиж дуусахад тариалангийн газар 125,845.86 га талбайгаар буурна гэж тусгасан байна. Аймгийн газар нутгийн хэмжээ хилийн цэсийн маргаан шийдвэрлэхээс бусад тохиолдолд өөрчлөгдөх боломжгүй юм. Гэтэл нэгдмэл сангийн өөрчлөлтийн хүснэгт 12.1-д 2,630,556.09 га-аар нэмэгдүүлсэн, тоон мэдээллийг зөрүүтэй тусгасан байна.

Хүснэгт 3. ГЗБЕТ-ний газрын нэгдмэл сангийн өөрчлөлт

№	Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал	Одоогийн байдлаар /2017 он/	Төлөвлөлтөөр /2030 он/	Өөрчлөлт /+, -/
1	хөдөө аж ахуйн газар	5,567,449.1	5,664,468.9	+97019.7
2	хот тосгон бусад суурин газар	86,726.0	145,107.1	+58381.1
3	зам шугам сүлжээний газар	45,354.0	80,326.4	+34972.3
4	ойн сан бүхий газар	573,123.2	1,486,101.5	+912978.3
5	усны сан бүхий газар	14,285.0	22,495.8	+8210.7
6	тусгай хэрэгцээний газар	1,117,299.6	2,636,293.4	+1518993.7
Аймгийн нийт талбай		7,404,237.0	7,404,237.0	

Эх сурвалж: Төв аймгийн ГЗБЕТ-ний 3 дугаар боть хүснэгт 12.1

Дээрх хүснэгтэд 2030 онд ГЗБЕТ хэрэгжиж дуусахад аймгийн газрын хэмжээ нийт дүнгээрээ өөрчлөгдөөгүй мэт боловч газрын ангилал бүрээр нэмэгдүүлсэн, 2030 оны нийт дүн 10,034,793.09 га болж 2,630,556.09 га-гаар зөрүүтэй тооцсоныг ГХБХБГ хянаж засварлаагүй, аймгийн ИТХ баталсан байна.

Сумын Засаг дарга нар газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэрэгжилтийг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж ажилладаг боловч сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулаагүй, иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээгээр эзэмшүүлэх газрыг нэгж талбар бүрээр газар зүйн солбилцлоор /2022 оноос өмнө/ нь төлөвлөөгүй байна. Энэ нь Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д зааснаар иргэн, ААНБ-д эзэмшүүлж, ашиглуулах үйл ажиллагаа нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ гэснийг баримтлаагүй нийтлэг зөрчил байна. Газар зохион байгуулалт төлөвлөлттэй холбоотой дараах зөрчил илэрлээ.

- Баянжаргалан сум автозамын гэр хороолол суурьшсан газрыг ногоон байгууламж, орон сууц, худалдаа үйлчилгээ, тээвэр зуучлалын бүс байхаар төлөвлөсөн. Авто замын трасс, гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэхээр төлөвлөсөн газарт орон сууц, барилга байгууламж, төрийн байгууллага баригдсан байна.
- Баянчандмань сум газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт тариалангийн зориулалтаар 14.9 га газар олгосон байна.
- Батсүмбэр сум усан сан бүхий газрыг суурьшлын бүс болгон иргэдэд өмчлүүлсэн, иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан газар эзэмшүүлэхдээ 2019 оны ГЗБТ-д тусгагдаагүй 1.4 га, тариалангийн зориулалтаар давуу эрхээр 407.7 га газар төлөвлөгөөнөөс хэтрүүлэн олгосон байна.

Зураг 1. Батсүмбэр сумын усан сан бүхий газрын суурьшлын бүс



Эх сурвалж: egazar.gov.mn/map

- Жаргалант сум Газрын тухай хуулийн 29.3 “Багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна”-т заасны дагуу тариалангийн газрыг үр тариа болон төмс хүнсний ногоо тарих зориулалтаар давуу эрхээр эзэмшүүлэхдээ 2019-2020 оны ГЗБТ-д зөвхөн газрын байршлын нэрээр төлөвлөж иргэнд эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг тусгаагүй байна.
- Мөнгөнморьт сумын ИТХ-ын шийдвэрээр баталсан ГЗБТ-г газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд зөрүүтэй оруулсан, Засаг даргын ГЗБТ-ний

хэрэгжилтийг ИТХ-аас дүгнэхдээ шийдвэр гарснаар тооцсон, газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд тухайн жилийн газар олголтын шийдвэрийг оруулаагүй хангалтгүй ажилласныг үр дүнтэй гэж дүгнэсэн байна.

- Зуунмод сум Хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх газрыг тусгайлан заагаагүйгээс суурьшлын холимог бүсэд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар олгохоор төлөвлөн олгосон. Суурьшлын холимог бүсэд орон сууц, гудамж талбай барьж байгуулахаар заасан байхад гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар олгохоор төлөвлөж олгосон байна.
- Баяндэлгэр сум ИТХ-ын шийдвэрээр баталсан ГЗБТ-г газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд зөрүүтэй оруулсан
- Баян сумын ИТХ-аас баталсан 2021 оны ГЗБТ-нд тусгагдаагүй үйлдвэр, тэсэрч дэлбэрэх бодисын агуулахын зориулалтаар 2 га газар олгосон байна.
- Сэргэлэн сумын ИТХ-аас баталсан Газар зохион байгуулалтын тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөг газар олгосон захирамжтай тулган шалгахад нэгж талбарын байршил, хэмжээг өөрчилсөн, шинээр олгосон 2019 онд 12 нэгж талбарын 392.8 га, 2020 онд 10 нэгж талбарын 459.0 га, 2021 онд 1 нэгж талбарын 5.0 га, 2022 онд 2 нэгж талбарын 41.7 га газрыг төлөвлөгөөнд тусгахгүйгээр олгосон зөрчил байна.
- Аймгийн Засаг даргын 2020 оны А/474 дугаар захирамжаар 2020 оны ГЗБТ-д тусгагдаагүй Номт 1-р багийн төвийн шугам сүлжээтэй 0.01 га газрыг 6 иргэнд үнэ төлбөргүй давуу эрхээр эзэмшүүлсэн.

Мөн сумын Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 27 сумаас Алтанбулаг, Аргалант, Баян сум батлуулж 24 сум нь батлуулаагүй байна. Иймд аймаг, сумын ГЗБ-ын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөө, Хотын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д заасан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон тэдгээрийн хоорондын уялдаа холбоог харгалзан, бодит судалгаа, мэдээлэлд үндэслэн боловсруулан баталж, мөрдүүлэх, түүний хэрэгжилтэд байнгын хяналт тавих шаардлагатай байна.

МУЗГ-ын 2021 оны 307 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрийн 19,390.4 га газрыг үндэсний хэмжээний бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсантай холбоотой нөлөөлөлд өртсөн иргэн, ААН-ийн 741 нэгж талбарын 1,246.5 га газрын байршлыг өөрчилж, 2023 оны А/493 дугаар захирамжаар 22.9 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна.

А.2. Гэр бүлийн хамтын хэрэгцээний газрыг ГЗБТ-нд тусгаагүй байршилд олгосон, хуульд заасан газрын хэмжээнээс илүү эзэмшүүлсэн зөрчил арилаагүй байна.

Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 29.3-т заасны дагуу тухайн орон нутгийн Засаг даргын захирамжаар Монгол Улсын иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан, тус зүйлд заасан хэмжээгээр газар эзэмшүүлэх зохицуулалттай байна. Аудитад хамрах хугацаанд аймаг, сумын Засаг даргын захирамжаар аймгийн хэмжээнд нийт 12,849 нэгж талбарт 11,645.6 га газрыг гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх шийдвэр гаргажээ.


Хүснэгт 4. Гэр бүлийн хамтын хэрэгцээгээр олгосон газрын судалгаа

№	Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан эзэмшүүлсэн газрын зориулалт	Нэгж талбарын тоо	Газрын хэмжээ /га/
1	Хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар	8753	669.5
2	Хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар	24	2.4
3	Иргэдэд давуу эрхээр тариалангийн үр тарианы зориулалтаар	1002	9,631.0
4	Иргэдэд давуу эрхээр төмс хүнсний ногооны зориулалтаар	374	1,136.3
5	Өвөлжөө, хаваржааны зориулалтаар	2696	206.4
Нийт		12849	11,645.6

Эх сурвалж: ГЗБГЗЗЕГ-аас ирүүлсэн Төв аймгийн газрын судалгаа

Зарим сумдын Засаг дарга, газрын даамал нар нь гэр бүлийн хамтын хэрэгцээний хувийн гэр, орон сууцны хашааны зориулалтай газрыг хуульд заасан хэмжээ 0.07 га-аас хэтрүүлэн олгох зөрчил давтан гарсаар байна.

Зураг 2. Газрын хувийн хэргийн хадгалалтын байдал




Аудитын хамрах хугацаанд аймаг, сумын Засаг даргын захирамжаар иргэдийн гэр бүлийн хамтын хэрэгцээнд газар олгосон шийдвэр, үйл ажиллагаатай холбогдох нэгж талбарын хувийн хэрэг, баримт материалыг түүвэрлэн нягтлан шалгалаа. Зарим сум нь нэгж талбар дээр хувийн хэрэг нээгээгүй, бүрдэл дутуу, хадгалалт, хамгаалалт стандартын дагуу биш, захирамжид дурдсан иргэний тоо, газрын хэмжээ нь хавсралтын дүнгээс зөрүүтэй, архивын нэгж баримтад хавсралтгүй үдсэн, өв залгамжлагчид газрын эрх шилжүүлэхдээ эзэмших хугацааг шинэчлэн тогтоосон, утга найруулгын хувьд ойлгомжгүй зэрэг нийтлэг зөрчил байхаас гадна дараах зөрчлийг илэрсэн.

Тухайлбал:

1. ГЗБТ-г газрын мэдээллийн нэгдсэн санд оруулдаггүйгээс төлөвлөгөөнөөс хэтрүүлэн газар олгодог зөрчил гарч байна. Аймгийн хэмжээнд нийт 958 нэгж талбарт иргэдийн гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар 102.7 га талбай бүхий газрыг тухайн жилийн ГЗБТ-д тусгагдаагүй байршилд эзэмшүүлж Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 31 дүгээр зүйлийн 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.4-д тус тус заасныг зөрчсөн байна.
Тухайн жилийн ГЗБТ-д тусгагдаагүй байршилд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар олгодог нь гэр хороолол төлөвлөлтгүй, эмх замбараагүй тэлэх нөхцөлийг бүрдүүлэх, агаар, ус, хөрсний бохирдол ихсэх зэргээр байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна.
2. Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар 0.07 га”-аас илүүгүй газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлэх, уг хэмжээнээс илүү олгох тохиолдолд дуудлага худалдаа, төсөл шалгаруулалтын зарчмаар шийдвэрлэхээр заасан. Гэтэл аудитын хамрах хугацаанд сумын Засаг даргын захирамжаар иргэдийн гэр бүлийн хамтын хэрэгцээнд нийт 1,258 нэгж талбарт 1,031.5 га газрыг хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн үнэ төлбөргүй эзэмшүүлсэн байна. /Хавсралт 2/.

Зураг 3. Баянчандмань сум 2.24 газрыг 1 иргэнд 0.07 га-аар 32 захирамж гаргаж олгосон газар



Мөн Баянчандмань сумын Засаг дарга гэр бүлийн хамтын хэрэгцээний зуслангийн зориулалттай дараалсан нэгж талбарыг нэг иргэнд 3-33 удаагийн захирамжаар хэсэгчилж олгосон, давуу эрхээр газар эзэмшүүлэхдээ нэг иргэнд 2-4 удаа олгосон шийдвэр гаргасан байна.

3. Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана” гэж заасан байна. Аудитад хамрагдах хугацаанд Сэргэлэн сум 24 иргэнд 1.7 га, Аргалант сум 2 иргэнд 3.1 га, Алтанбулаг сум Заамар сум 1.5 га газрыг 18 нас хүрээгүй Монгол Улсын иргэнд газар эзэмшүүлсэн.
4. Давуу эрхээр газар олгохдоо МУЗГ-ын 2003 оны 28 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт “Тариалангийн газрыг давуу эрхээр эзэмшүүлэх журам”-ыг үндэслэн иргэдэд үр тариа, төмс хүнсний ногооны зориулалтаар 1028 нэгж талбарт 2,241.9 га газар эзэмшүүлсэн байна. Давуу эрхээр олгосон газрын хувийн хэргийг үзэхэд иргэний газар хүссэн өргөдөл, багийн Засаг дарга, ИНХ-аар хэлэлцэж ирүүлсэн материал, кадастрын зураглал, газар эзэмшүүлэх гэрээ болон давуу эрхийг нотлох баримт байхгүй, хувийн хэргийн бүрдэлгүй, тариалангийн салбарт гурваас доошгүй жил ажиллаж түүний ургацын борлуулалтаас үндсэн орлогоо олж байгаа болон байсныг нотлох баримтгүй байхгүй нийтлэг зөрчил байна. Үүнээс МУЗГ-ын 2018 оны 05 сарын 16-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор баталсан тариалангийн бүс нутагт хамаарахгүй Мөнгөнморьт, Баяндэлгэр, Эрдэнэ, Баян сумдад 135.0 га газрыг давуу эрхээр олгожээ. Давуу эрхээр газар эзэмшсэн иргэдийн 614 нэгж талбарын 1,078.3 га газрыг буюу 48,1 хувийг нь бусдад эрх шилжүүлсэн байна. /Хавсралт 2/

Сумын Засаг дарга, газрын даамал нь гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалттай газар эзэмших эрх, тариалангийн зориулалттай газрыг давуу эрхээр эзэмшүүлэхдээ хууль тогтоомжийг мөрдөж, ёс зүйтэй, хариуцлагатай байх, нөгөө талаас ГХБХБГ-аас тавих хяналтыг сайжруулах, ашиг сонирхлоос ангид байх шаардлагатай байна.

А.3. Иргэн, хуулийн этгээдэд 552,2 сая төгрөгийн анхны үнэтэй 221 га газрыг дуудлага худалдаагүй эзэмшүүлсэн байна.

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд газар эзэмшүүлэх зохицуулалттай байна.

Аймаг, сумын Засаг даргын захирамжаар 2019-2023 онд нийт 2175 нэгж талбар бүхий 77,444.0 га газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх шийдвэрийг гаргасан байна.

Хүснэгт 5. Иргэн ААН-д эзэмшүүлсэн газар /зориулалтаар/

№	Эзэмшүүлж, ашиглуулахаар олгосон газрын зориулалт	Нэгж талбарын тоо	Газрын хэмжээ /га/
1	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	403	1,014.4
2	ХАА-н үйлдвэрлэл	296	2,386.8
3	ХАА-гаас бусад үйлдвэрлэл	45	246.9
4	Төсөвт байгууллагын албан хэрэгцээ	437	20,939.4
5	Тариалан	944	32,756.0
6	Бэлчээр	0	-
7	Уул уурхай	50	20,100.5
Нийт дүн		2175	77,444.0

Эх сурвалж: ГЗБГЗЗЕГ-аас ирүүлсэн Төв аймгийн газрын судалгаа

Сумын Засаг дарга нар газрын эрх эзэмшүүлэхдээ газрын хэд хэдэн зориулалтыг давхардуулан захирамжилдаг зөрчил нийтлэг байна. Тухайлбал төмс хүнсний ногоо-үр тариа, жимс жимсгэнэ-үр тариа гэх мэт

График 2. Газрын олголтын зөрчлийн ангилал



Эх сурвалж: Сумын Засаг даргын захирамж, судалгаа

Мөн МУЗГ-ын 2018 оны 182 дугаар тогтоол “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоолд бусад сумын төв (хот, тосгон, бусад суурины газар)-ийн газрын суурь үнэлгээнд газрын зориулалтыг тодорхой заагаагүйгээс газрын дуудлага худалдааны үнийг тооцохдоо зориулалтыг харилцан адилгүй сонгож байна. Тухайлбал жимс, жимсгэний мод тариалах зориулалттай газрын дуудлага худалдааны анхны үнийг тариалангийн төмс, хүнсний ногоо бусад ургамал тариалах зориулалтаар, өвөлжөө, хаваржааг ХАА-н зориулалтаар тооцдог зэрэг зөрүүтэй ойлголтууд гарч байна.

Аймаг, сумын Засаг дарга нь Газрын тухай хууль, МУЗГ-ын тогтоолуудыг зөрчиж төсөл сонгон шалгаруулалтын шаардлага хангаагүй, дуудлага худалдаа зохион байгуулаагүй, тариалангийн газрыг давуу эрхээр ААН-д эзэмшүүлсэн, төсөвт байгууллага нь эзэмшил газраа бусдад шилжүүлсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

1. Мөнгөнморьт сумын ИТХ-ын баталсан ГЗБТ-нд тусгагдаагүй 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй газартай холбоотой 470.4 га газар, буга үржүүлгийн газар 98.9 га, 2020 онд гэр, орон сууцны хашааны зориулалтаар эзэмшүүлэх газар 6.2 га, хорих ангийн хамгаалалтын бүс тогтоох зориулалтаар 312.9 га газар эзэмшүүлсэн
2. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг ГЗБТ-ний дагуу тухайн шатны Засаг даргын захирамжаар эзэмшүүлэхээр заасны дагуу 2019-2023 оны хугацаанд улсын хэмжээнд нийт 437 нэгж талбарт 20,939.4 га талбай бүхий газрыг төрийн байгууллагад эзэмшүүлжээ. Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”, МУЗГ-ын 2020 оны 10 дугаар тогтоолын дагуу төсөвт байгууллагуудад газрыг гэрчилгээжүүлсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Холбогдох хууль тогтоомжид “төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газар” гэх ангилалд хамаарах газрын хэмжээ, ашиглалтын зориулалт, тус газар дээр явуулах үйл ажиллагаа зэргийг нарийвчилсан тодорхой зохицуулаагүйгээс төрийн байгууллагын нэрээр ажилчдын зуслан, амралтын газар, орон сууц, төмс, хүнсний ногоо, үр тариа тариалах зэрэг зориулалтаар 0.1-1500 га хүртэл хэмжээгээр газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлсэн байна. Тухайлбал: Газар тариалангийн зориулалтаар Алтанбулаг сум 913 га, Эрдэнэ 140 га, Баянжаргалан 1000 га, Сэргэлэн 100 га, Баян 1500 га, орон сууцны зориулалтаар БЗОСК ОНӨААТҮГ 0.59 га, Сэргэлэн сумын ЗДТГ 1 га, Төв Эрдэнэс ОНӨҮГ 49 га газар эзэмшсэн байна. Төсөвт байгууллага нь өөрийн эзэмшилд байсан газрыг бусдад шилжүүлсэн нь МУЗГ-ын “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 10 дугаар тогтоолын 7 дугаар зүйлийг зөрчсөн байна. Үүнд:


- Борнуур сумын Засаг даргын 2021 оны А/223 дугаар захирамжаар ЕБС-ийн эзэмшиж байсан 0.1922 га газраас 0.1153 га газрыг зориулалтыг өөрчлөн "Ану сервис" ХХК-д үндэслэлгүй шилжүүлсэн.
- Баянжаргалан сумын Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/79 дүгээр захирамжаар ЗДТГ-ын эзэмшилд байсан 1613 м² газрыг "Арвайн элч" ХХК-д газар эзэмших эрхийг шилжүүлэхдээ газрын хэмжээг 2100 м² болгон нэмэгдүүлсэн байна. Захирамжид үндэслэсэн сумын ИТХ-ын 2019 оны 05 дугаар тогтоол нь ЗДТГ-ын газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай заалт байхгүй байна. Мөн хувийн хэргийг шалгаж үзэхэд ижил огноо, дугаартай, "Өв Баян-Улаан" ХХК-д эрх шилжүүлэн эзэмшүүлсэн захирамж давхардуулан гаргасан.
- Жаргалант сумын ЗДТГ-аас 5 иргэн, ААН-д нийт 21.7 га газрын эрхийг үндэслэлгүй шилжүүлсэн байна.
- Аймгийн Засаг даргын 2020 оны А/516 дугаар захирамжаар Төв аймгийн Цагдаагийн газар орон сууцны зориулалттай 0.1266 га газрыг иргэн рүү шилжүүлсэн байна.

Дээрх байдлаар дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар олгох зохицуулалтад хамаарах газрыг төсвийн байгууллагын нэрээр үнэ төлбөргүй эзэмшүүлж, бусдад давуу байдал үүсгэж байгаа нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан “газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах” зарчимд нийцэхгүй байна. Иймд Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5, 27.6, 33 дугаар зүйлийн 33.1.1-д тус тус заасны дагуу эзэмшүүлэх газрын хэмжээ, зориулалт, төлбөр, хураамж, эзэмшүүлэх арга зам, тухайн газар дээр явуулах үйл ажиллагаа зэргийг нарийвчлан зохицуулж боловсронгуй болгох шаардлагатай байна.

3. Зуунмод, Эрдэнэ сумд нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д “хүний үйл ажиллагааны улмаас элэгдэл, эвдрэлд орж, ашиглалтгүй орхигдсон газрыг өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн газрыг ... эзэмшүүлж болно” гэж заасны дагуу 4 нэгж талбарт 1.4 га газар олгохдоо байгаль орчны газрын дүгнэлтийг үндэслээгүй /Зуунмод сумын газрын даамал нь газрын

- дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, нөхөн сэргээлт хийсэн иргэн ААН-ийн холбогдох материалыг аудитын хугацаанд ирүүлээгүй/ олгосон байна.
- Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д “Багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно.” гэж заасан. Аудитын хамрах хугацаанд Батсүмбэр сумын Засаг дарга нь “Батсүмбэр баяжих” хоршоонд 20 га, “Агро-Альфа” ХХК-д 186 га, “Өнөр мандал” ХХК-д 13 га, 2020 оны А/234 дүгээр захирамжаар 4 га, нийт 4 аж ахуйн нэгжид 223 га газрыг давуу эрхээр эзэмшүүлсэн байна.
 - Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх газар эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.” гэж заасныг зөрчиж 194.2 сая төгрөгийн дуудлага худалдааны анхны үнэтэй 134 нэгж талбар 241 га газрыг дуудлага худалдаагүй эзэмшүүлсэн. Мөн МУЗГ-ын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-д заасан шаардлагыг хангаагүй 8 төсөлд 195.5 сая төгрөгийн дуудлага худалдааны анхны үнэтэй 42 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн байна. /Хавсралт 3/
Мөн захирамжид заасан газрын хэмжээнээс илүү газар эзэмшсэн 152 иргэн ААН-д кадастрын зурагтай зөрсөн гэсэн үндэслэлээр газрын хэмжээг нэмж өөрчлөн шийдвэрлэхдээ 9 иргэн, ААН-ээс дуудлага худалдааны анхны үнэ 16.4 сая төгрөгийг төлүүлж бусад иргэн ААН-д үнэ төлбөргүй эзэмшүүлжээ.
 - Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6-д “Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно” гэж заасан. Алтанбулаг сум Туул голын дагуу жимс, жимсгэний зориулалтаар 14 нэгж талбарт 154.1 га, Батсүмбэр сум аялал жуулчлалын амралтын газрын зориулалтаар 5 нэгж талбарт 95.5 га, төмс хүнсний ногооны зориулалтаар 6 нэгж талбарт 29 га газар эзэмшүүлсэн.

Зураг 4. Алтанбулаг сум Туул голын эрэг дагуу жимс жимсгэнэ зориулалттай газар




БҮЛЭГ 2. ГАЗРЫН ЭРХ ШИЛЖҮҮЛСНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР, ГАЗРЫН ТӨЛБӨР, УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙГ НОГДУУЛААГҮЙ, ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Б.1. Аймгийн хэмжээнд 2019-2023 онд 24,151.2 га газрыг дуудлага худалдаагаар эзэмшүүлж, төсөвт 23,345.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх газар эзэмшүүлэх асуудлыг аймаг, сумын Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу ГЗБТ-д тусгагдсан нийт 1131 нэгж талбарын 24151.2 га газрыг дуудлага худалдааг зохион байгуулж орон нутгийн төсөвт 23,345.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

График 3. Газрын дуудлага худалдааны орлого



Эх сурвалж: Газрын дуудлага худалдааны төрийн сангийн харилцах дансны хуулга

Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр хуралдааны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дугаар хэсэгт газрын дуудлага худалдааны орлогыг аймгийн төрийн сангийн газрын биржийн 100140000967 дугаар дансанд төвлөрүүлж, орлогыг газрын дуудлага худалдаа зохион байгуулсан суманд 50 хувь, аймгийн ГХБХБГ-т 10 хувь, аймагт 40 хувь хуваарилахаар тогтоосон байна. Төрийн сангийн газрын биржийн 100140000967 дугаар дансанд 2021 онд 1,028.7 сая төгрөг, 2022 онд 6,976.9 сая төгрөг, 2023 онд 5,274.7 сая төгрөг төвлөрүүлж, хуваарилсан байна. ГХБХБГ-ын 10 хувиас байгууллагын урсгал зардал болох томилот, шатахууны зардал, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зардал зарцуулахаар журамласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-т “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, 6.6.6-т “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 27 дугаар зүйлийн 27.2.1-т “төсвийн хязгаарыг урсгал болон хөрөнгийн зардлаар тогтоосон байх” гэсэн заалтыг тусгасныг зөрчиж байна.

МУЗГ-ын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 11.3-д “Дуудлага худалдааны ялагч гэрээ байгуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор энэ журмын 11.2-т заасан дуудлага худалдааны үнийг бүрэн төлнө” гэсэн заалтыг зөрчиж Сэргэлэн сум 2023 онд газрын дуудлага худалдааны ялагч 2.1 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Б.2. Газар эзэмшүүлэх, эрх шилжүүлэх, эрхийн гэрчилгээг сунгахтай холбоотой татвар, хураамжийг иргэн, ААН-д ногдуулж төсөвт төвлөрүүлээгүй байна.

ХХОАТ-ын тухай хууль, ААНОАТ-ын тухай хуульд газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогод хуульд заасан хувь хэмжээгээр ногдуулж төсөвт төвлөрүүлэхээр хуульчилсан байна. Сангийн сайдын 2019 оны 30 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал”-ын дагуу газрын эрхийн татвар ногдох үнэлгээг тооцохоор баталсан байна.

Аудитын хамрах хугацаа 2019-2023 онд аймгийн хэмжээнд 5935 нэгж талбарын 53,044.6 га газрын эрх шилжсэн байна.

Хүснэгт 6. Эрх шилжүүлсэн газар /зориулалтаар/

№	Газрын зориулалт	Нэгж талбар тоо	Газрын хэмжээ /га/	Эрх борлуулсны үнэ	Ногдсон албан татвар
1	Гэр бүлийн хамтын хэрэгцээ	3770	392.8	2,256,455.4	225,645.54
2	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	622	2395.3	19,162,047.2	3,104,251.65
3	Тариалан	1114	48359.6	3,863,928.6	463,671.43
4	Төсөвт байгууллагын албан хэрэгцээ	18	5.2		-
5	ХАА-гаас бусад үйлдвэрлэл	46	213.3	1,365,331.2	178,858.39
6	ХАА-н үйлдвэрлэл	365	1678.6	8,057,040.5	1,137,654.12
Нийт дүн		5935	53044.6	34,704,802.9	5,110,081.1

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын судалгаа

Газрын эрх шилжүүлсэн захирамж, хувийн хэрэг, гэрээ, анхан шатны баримтыг тулгахад эрх шилжүүлж байгаа гэрээнд үнийн дүн байхгүй, хувийн хэрэгт татвар төлсөн баримтгүй, газрын эрхийг шилжүүлэх үед татвар төлөх үүргээ биелүүлээгүй, татварын хэмжээг буруу тооцсон, жимс, жимсгэний зориулалттай газрыг тариалангийн зориулалтаар тооцож татвар ногдуулсан байна. Мөн сумын Засаг дарга, газрын даамал, татварын байцаагч нарын ажлын уялдаа муу байгаа зэргээс шалтгаалсан газрын эрх шилжүүлсний орлогын албан татвар төлөгдөхгүй байгаа зөрчил нийтлэг байна. Аудитын хамрах хугацаанд 1,424.6 сая төгрөгийн албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 793.2 сая төгрөгийн газрын эрх шилжүүлсний орлогын албан татварыг ногдуулаагүй, орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.

Мөн дуудлага худалдаагаар авсан газрын эрхийг шилжүүлэхдээ худалдан авсан үнээс нь татвар тооцоогүй дуудлага худалдааны анхны үнээс татвар тооцсон байна. Тухайлбал Зуунмод сумын амины орон сууцны газрыг дуудлага худалдаагаар авсан 8 нэгж талбарын 0.24 га газрыг 156.0 сая төгрөгөөс тооцолгүй дуудлага худалдааны анхны үнэ 1.3 сая төгрөгөөс татвар тооцсон нь 15.5 сая төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 303 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал”-ын 2.2-т “Энэ аргачлалын 2.2, 2.3 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд тухайн газрыг дуудлага худалдаагаар авахад шалгарсан үнэ болон татвар төлөгчөөс мэдүүлсэн газрын эрх худалдах, худалдан авах гэрээний үнийн аль өндөр үнээр газрын эрхийн үнэлгээг тодорхойлно” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Хүснэгт 7. Газрын эрх шилжүүлсний орлогын албан татварын дутуу төлөлт

№	Хамрагдсан сумд	Төлсөн дүн	Дүн
1	Баянчандмань	45.8	54.0
2	Батсүмбэр	58.5	42.4
3	Жаргалант	46.0	15.7
4	Борнуур	43.2	33.4
5	Мөнгөнморьт	9.2	30.1
6	Баяндэлгэр	9.7	12.1
7	Эрдэнэ	365.3	178.7
8	Баянжарглан	-	0.6
9	Баян	36.5	266.8
10	Сэргэлэн	688.3	48.4
11	Заамар	0.7	16.5
12	Аргалант	91.6	48.8
13	Баянхангай	11.7	19.5
14	Алтанбулаг	18.3	18.0
15	угтаал	25.8	8.1
Нийт дүн		1,424.6	793.2

Эх сурвалж: Эрх шилжүүлсэн захирамж, төрийн сангийн хууль

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Төрийн эрх бүхий байгууллагаас энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж /цаашид “тэмдэгтийн хураамж” гэх/ гэнэ”, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох, газрын хэвлийг олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана” гэж заасан байна.

